



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№23 /467/

2023.02.01

Цаг үе, үйл явдал

## МАЛЧДАД ТЭЖЭЭЛ ХҮРГЭЖ ЗАМ ГАРГАЖЭЭ



Ховд аймгийн Булган суманд олон жилийн дунджаас их хэмжээний цас орж өвөлжилт хүндэрсний улмаас зарим айл өрхүүд цасанд боогдож өвс, тэжээлээ тээвэрлэх боломжгүй болжээ.

Иймд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305 дугаар тусгай салбараас ахлах ахлагч С.Галбадрахаар ахлуулсан долоон цэргийн алба хаагч, нэг нэгж техниктэйгээр 1-р сарын 27-ноос 30-ны өдрүүдэд Ховд аймгийн Булган сумын Баянгол, Байтаг багийн хоёр чиглэлд 11 малчин айл өрхөд 1.5тонн тэжээл, 150 боодол өвс хүргэж, цасанд боогдсон хоёр айл өрхийг нүүлгэн шилжүүлж, 190 км газар зам гаргаж малчдыг чөлөөтэй зорчих боломжоор хангасан байна.

Уг ажилд оролцсон бие бүрэлдэхүүнд орон нутгийн удирдлага, малчдын зүгээс чин талархлаа илэрхийлсээр байна.



## ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЛЭЭ



эмэгтэйд тусалцаа үзүүлжээ. Тодруулбал, тэднийг маршрутын дагуу эргүүлийн үүрэг гүйцэтгэж байх үед нэгэн жирэмсэн эмэгтэйн биеийн байдал нь муудсан бөгөөд түүнийг НҮБ-ын баазад байрлах "Хил хязгааргүй эмч нарын эмнэлэг"-т шуурхай хүргэж өгсний үр дүнд уг эмэгтэй цаг алдалгүй эмнэлгийн тусламжийг авсны үр дүнд эсэн мэнд амаржсан байна.

Мөн нэгдүгээр сарын 26-ны өдөр ахлах ахлагч М.Сайнбаяраар ахлуулсан эргүүлийн бүлгийг үүрэг гүйцэтгэж байх үед орон нутгийн 3 иргэнд эмнэлгийн яаралтай тусламж авах шаардлага гарсан бөгөөд энэ үед ухаан алдсан нэг иргэнийг орон нутгийн

эмнэлэгт шуурхай тээвэрлэн хүргэж өгсөн байна. Энэхүү үйл явцыг харсан орон нутгийн иргэд Монгол Улсын цэргийн багийн энхийг сахиулагчдад талархлаа илэрхийлжээ.

Ийнхүү цэргийн багийн бүрэлдэхүүн ажиллагааны газар оронд шилжин байрлаад удаагүй байгаа хэдий ч үндсэн үүрэг гүйцэтгэлт жигдэрч, ажиллагааны тогтсон журам, удирдлагын баримт бичгийн хэрэгжилтийг ханган Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсын иргэдийн амгалан тайван амьдралын төлөө үүргээ амжилттай гүйцэтгэж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэн ажиллаж байна.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах UNMISS ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүн "Юнити" сектороос гадна Зүүн секторын Бор сууринд мотобуудлагын ротын бүрэлдэхүүнээр үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

Цэргийн баг Нэгдсэн Үндэстний Байгууллагын баазын харуул хамгаалалтаас гадна үер усны нөхцөл байдлаас шалтгаалан дүрвэгсдийн хуаран, НҮБ-ын ажилчдын байрлаж буй хэсгийн

дундах зэвсэггүй бүсэд явган болон хуягт тээвэрлэгчтэй эргүүлийг явуулж, иргэдийг үерийн усанд унах, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах, болзошгүй түрэмгийлэл, халдлага үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг үүргүүдийг гүйцэтгэж байна.

Тэгвэл хэдхэн хоногийн өмнө буюу энэ оны 01 дүгээр сарын 20-ны өдөр уг зэвсэггүй бүсэд үүрэг гүйцэтгэж байсан ахлах ахлагч Б.Баасан-Очиороор ахлуулсан бүлэг дотоодын дүрвэгсдийн хуаранд эргүүлийн үүрэг гүйцэтгэж явах үедээ орон нутгийн нэгэн жирэмсэн

## "ЭНЭ ЦАГИЙН СОНСОГЧИД, ИРЭЭДҮЙН ГЕНЕРАЛУУД"



ҮБХИС-ийн сургалтын хэлтэс, цэргийн албаны хэлтэс, соёл хүмүүжлийн тасаг, сонсогч оюутны холбоотой хамтран бүрэлдэхүүн сургуулиудын салааны захирагчийн орлогч, тасгийн захирагч, сонсогчдын сахилга хариуцлагыг сайжруулах, удирдах арга барилыг дээшлүүлэх, практик дадлага олгох цэргийн шинэчлэгдсэн дүрмийг таниулан сурталчлах зорилготой сургалтыг зохион байгууллаа.

Цэргийн алба эрхэлсэн тэргүүн дэд захирал хурандаа Э.Энхзоргол сургалтыг нээж хэлсэн үгэндээ цэргийн хүн болохоор сэтгэл шулуудаж тангараг өргөсөн л бол энэ албанаас урхач, урвах ямар ч шалтгаан байж болохгүй.

Сургалт бэлтгэлийн явцад болон ажил амьдрал дээр тохиолддог түрхэн зуурын зовлон бэрхшээл, бие махбодын болон сэтгэл санааны хямралыг даван туулах сэтгэлийн хат, хүмүүжил мөрдөстэй хүн бүхэнд заавал байх ёстойг онцлоод нийт бие бүрэлдэхүүнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөв.

Сургалтаар нийт бие бүрэлдэхүүн, ажлын байран дээр тохиолдож болзошгүй эрсдэл, харилцааны зөрчил, албаны хариуцлага, алба хаагчийн ёс зүй, манлайлал гэсэн сэдвийн хүрээнд кейс дээр ажиллаж зөв гарц гаргалгааг өөрсдөө олж шийдвэрлэхэд суралцсан юм.

Ахмад Д.ГАНЦЭЦЭГ

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-11	-29

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	23

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,503	3,509
EUR	3,815	3,825
CNY	518	519.50
RUB	48.50	48.80
JPY	27.15	27.35
KRW	2.84	2.86

### ЗУРХАЙ



**ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР**  
**ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ЦАГААН БАР ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**Эрхтэн хурц болно**  
**Наран ургах, шингэх:**  
**08.20-17.51**  
**Барилдлага:**  
**Үл зохилдох**  
**Шүтэн барилдлага:**  
**Төрөхүй**

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олодох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 675,217,937

Эдгэрсэн

Нийт: 647,632,276

Нас барсан

Нийт: 6,762,458

## ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ЦЭРГИЙН ХЭРГИЙН МЭДЛЭГЭЭРЭЭ ӨРСӨЛДЛӨӨ



Зэвсэгт хүчний 119, 120, 326 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлэх зорилготой "Тактик жагсаалын нэгдсэн хичээл"-ийн хоёрдугаар шатны арга хэмжээ 1 дүгээр сарын 30-ны өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар ангид амжилттай явагдлаа. Энхий шат нь Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид явагдсан юм.

Уг тактик жагсаалын хичээл нь уламжлалт бус шинэлэг хэлбэрээр зохион байгуулагдсан ба дээрх гурван ангийн хугацаат цэргийн алба хаагчийн дунд цэргийн хэргийн мэдлэг, дадлага, чадвар, биеийн тамир спорт, оюун ухааны чадавхыг сорьсон уралдаан тэмцээн явуулснаараа онцлог юм.

Энэ өдөр түрүүч, байлдагч нар ангийн үйл ажиллагааны онцлог, зэвсэглэл, цэргийн техниктэй танилцаж,

хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу "Тусгай бэлтгэлийн нормативын буухиа", танин мэдэхүйн асуулт хариултын "АХА" тэмцээнд оролцлоо. Анги тус бүрээс 7 гишүүнтэй 2 баг "Тусгай бэлтгэлийн нормативын буухиа"-д оролцож аваргаа тодруулсан бөгөөд гишүүн бүр 1 нормативыг биелүүлж, дарцаг дамжуулан уралдаж, барианд орсон юм.

Ингээд тэмцээний дүнгээр Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн нэгдүгээр баг, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн хоёрдугаар баг, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн нэгдүгээр баг тус тус тэргүүлж, өнгөлөв.

Мөн Монгол Улсын түүх, газар зүй, соёл уламжлал, "Цэргийн нийтлэг дүрмүүд", танин мэдэхүйн хөгжөөнт асуулттай "АХА" тэмцээнд анги бүрээс 20 хугацаат цэргийн алба хаагч

оролцоход байлдагч Л.Занданшатар, Э.Гансүх (326), байлдагч М.Төгс-Од (119) нар эхний байруудад шалгарсан юм.

Ахмад Ц.ЭРДМИЙНТУЯА



## 160 ГАРУЙ АЖИЛТАН АЛБА ХААГЧИД ГЭР БҮЛИЙН ХАМТ "ЧИНГИС ХААН-ҮНДЭСНИЙ МУЗЕЙ"-ТЭЙ ТАНИЛЦЛАА



Зэвсэгт хүчний 150 дугаар анги ажилтан, алба хаагчдынхаа түүхийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 160 гаруй цэргийн гэрээт алба хаагч болон офицер, ахлагчийн төлөөллийг гэр бүлийнх нь хамт "Чингис хаан-Үндэсний музей"-гээр аялууллаа.

Чингис хаан-Үндэсний музей нь үе үеийн хаадын түүх, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээсэн өв соёлыг цогцоор нь харуулж, цэргийн алба хаагчдын оюуны мэдлэгийг дээшлүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлснээрээ ач холбогдолтой байлаа.

Тус анги нь Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар анх удаа цэргийн гэрээт алба хаагчтай болсноор тэдний бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлд онцгой анхаарсан ажил арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байгаа юм.



## ӨВ СОЁЛ, ҮҮХ ТҮҮХЭЭ СУРТАЛЧИЛСАН ӨДӨР...



"Харуул" багууд тус тус шалгарч бусад нөхдөө манлайлсан юм.

Энэхүү тэмцээн нь Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирэх хоёрдугаар сард зохион байгуулах "Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр"-т оролцох авьяаслаг бүрэлдэхүүнийг шалгаруулахад чиглэсэн юм.



Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Цэргийн цагдаагийн ротоос үндэсний өв соёл, дуу хуур, тоглоом наадгай, түүх шаштир, утга зохиол, бичгийн соёлын өв уламжлалаа ирээдүй хойч үедээ түгээн дэлгүүлэх, сурталчлан таниулах зорилгоор "Цагаан сар монгол түмний их баяр" тэмцээнийг зохион байгуулжээ.

Тэмцээнд таван баг оролцож мэндчилгээ, заавал дуулах дуу, "Дэмбээ" наадгай, шагай шүүрэх, сээр цохих гэсэн таван төрлөөр өрсөлдсөнөөс тэргүүн байрт Үлээвэр найрал хөгжим, Цэргийн гал тогоо, Үйлчлэх хэсгийн хамтарсан "Цагаан сүлд" баг, дэд байрт Харуул үйлчилгээний тусгай рот, Эрүүл мэндийн төвийн хамтарсан "Хөсөгтөн" баг, гутгаар байрт Цэргийн цагдаагийн ротын

## ЗАРИМ АЛБАН БАЙГУУЛЛАГА, ЗОРИЛТОТ БҮЛГИЙН АЙЛ ӨРХҮҮДЭД ТУСЛАМЖИЙН ГАРАА СУНГАЛАА



Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн ангийн нийт бие бүрэлдэхүүн нийгмийн хариуцлагын хүрээнд "Эерэг хандлага Эв нэгдэл" сэдэвт аяныг зохион байгуулж зарим албан байгууллага болон зорилтот бүлгийн айл өрхүүдэд эд бараа, материалын дэмжлэг үзүүлэн чин сэтгэлийн хандив өргөлөө.

Тухайлбал, БЗД-ийн наймдугаар хороонд байрлах "СОС" асрамжийн газрын багачуудын номын санг 45 багц номоор баяжуулсан бол БЗД-ийн 19-р хорооны зорилтот бүлгийн 10 айл өрхөд хоол

хүнсний материал, дулаан хувцас, түлээ нүүрсний эд зүйлсээр туслалцаа үзүүлсэн юм.

Долоон хоногийн хугацаанд зохион байгуулсан тус аянд ангийн нийт бие бүрэлдэхүүн ажилтан, алба хаагчид идэвх санаачилгатай оролцсон бөгөөд Зэвсэгт хүчний мөрдэс нэгт нөхдөө уг аянд нэгдэхийг уриалж байна.

САЙН ҮЙЛС БҮХЭН ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ

Дэслэгч Б.ЭНХМАНЛАЙ